

Сонгинохайрхан
дүүргийн ЗСМГ-Т



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 25/21


Улаанбаатар хот

Хороодын бүтэц, зохион байгуулалтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор өрх, хүн амын тоо, газар нутгийн хэмжээг харгалзан Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд шинээр байгуулах 17 хороог нэгдүгээр хавсралтаар, хороодын хүн амыг тэнцвэржүүлэх зорилгоор Сонгинохайрхан дүүргийн зарим хороодын хүн ам, хилийн цэсийн өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Хороодыг шинээр байгуулах, зохион байгуулалтын өөрчлөлт хийхэд шаардагдах зардлыг 2020 оны төсөвт тусгуулан хэрэгжилтийг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д даалгасугай.

ДАРГА  РДАГВА




Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
25/21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



ШИНЭЭР БАЙГУУЛАГДАХ ХОРООДЫН ЖАГСААЛТ

№	Хуваах хороод	Шинээр байгуулагдах хороод
Нэг. Налайх дүүрэг		
1	2 дугаар хороо	8 дугаар хороо
Хоёр. Сонгинохайрхан дүүрэг		
2	1 дүгээр хороо	34 дүгээр хороо
3	2 дугаар хороо	35 дугаар хороо
4	6 дугаар хороо	37 дугаар хороо
5	7 дугаар хороо	40 дүгээр хороо
6	18 дугаар хороо	38 дугаар хороо
7	22 дугаар хороо	33 дугаар хороо
8	23 дугаар хороо	39 дүгээр хороо
9	24 дүгээр хороо	41 дүгээр хороо
10	25 дугаар хороо	42 дугаар хороо
11	26 дугаар хороо	36 дугаар хороо
12	31 дүгээр хороо	43 дугаар хороо
Гурав. Хан-Уул дүүрэг		
13	2 дугаар хороо	20 дугаар хороо
14	3 дугаар хороо	
15	10 дугаар хороо	21 дүгээр хороо
16	11 дүгээр хороо	17 дугаар хороо
17	15 дугаар хороо	18 дугаар хороо
		19 дүгээр хороо
Нийт		17 хороо

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
25/21 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



ХИЛИЙН ЦЭСЭД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ ХОРООД

Хороо	Тайлбар
Нэг. Сонгинохайрхан дүүрэг	
14 дүгээр хороо	<i>Хасагдаж байгаа хэсэг:</i> 81 дүгээр сургуулийн баруун талын 44-1, 44-2 дугаар байрны 0.8 га га газрыг 15 дугаар хорооны газар нутагт нэмэх <i>Нэмэгдэж байгаа хэсэг:</i> Байхгүй
15 дугаар хороо	<i>Хасагдаж байгаа хэсэг:</i> Байхгүй <i>Нэмэгдэж байгаа хэсэг:</i> 14 дүгээр хорооны 81 дүгээр сургуулийн баруун талын 44-1, 44-2 дугаар байрны 0.8 га га газрыг 15 дугаар хорооны газар нутагт нэмэх
21 дүгээр хороо	<i>Хасагдаж байгаа хэсэг:</i> 369-н гарам, Хүй 7 худаг, Давааны зөрлөг орчмын 130 өрхийн 316 хүн амыг 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт нэмэх <i>Нэмэгдэж байгаа хэсэг:</i> Байхгүй
30 дугаар хороо	<i>Хасагдаж байгаа хэсэг:</i> Чулуутын 1 дүгээр гудамжны 1.8га газар нутгийг 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт нэмэх <i>Нэмэгдэж байгаа хэсэг:</i> Байхгүй
32 дугаар хороо	<i>Хасагдаж байгаа хэсэг:</i> Байхгүй <i>Нэмэгдэж байгаа хэсэг:</i> 21 дүгээр хорооны 369-н гарам, Хүй 7 худаг, Давааны зөрлөг орчмын 130 өрхийн 316 хүн амыг 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт нэмэх